



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

Хангарди ордон, Нийслэлийн засаг захиргааны II байр,
Ц.Жигжиджавын гудамж-9, Бага тойруу-3, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: 7010-1388, 7010-1408
E-mail: contact@internalaudit.ub.gov.mn
<http://www.internalaudit.ub.gov.mn>

2019.11.22 № 04/196
танай _____ -ны № _____ -т

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Амарсайханы баталсан 2019 оны 22 дугаар удирдамжийн дагуу хийсэн гүйцэтгэл, нийцлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн асуудлын хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт 30 хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Я.САРАНСҮХ

1150000320

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Аудит хийгдсэн байгууллага:

“Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар”

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР :

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2018, 2019 оны
үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх

Аудитын хугацаа: 2019.08.26-2019.10.04

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АБТ	Ажлын байрны тодорхойлолт
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
МУ	Монгол улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДАГ	Нийслэлийн Дотоод аудитын газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХААГ	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
СХШУАБ	Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨТ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨӨЗ	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХО	Хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮХ	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

1. Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх зорилтын хүрээнд:

Тухайн зорилтын хүрээнд аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд дотоод хяналт сул, хяналт, шинжилгээ үнэлгээний болон дотоод аудит хариуцсан мэргэжилтэнгүүд захиргаа болон хуулийн хэлтэст харьяалагдсан, стратеги төлөвлөгөөг хангалттай сайн боловсруулж чадаагүйн улмаас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаагүй, албан тушаалын тодорхойлолтод заагдаагүй болон зарим албан хаагчдад хэт давуу байдал үүсгэн үнэлгээний хороонд ажиллуулсан, ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг харилцан адилгүй буюу тухайн албан хаагчид тохируулж тогтоосон зэрэг асуудлууд илэрлээ.

2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжсэн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хууль, тогтоомжийн нийцэл хангасан байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилтын хүрээнд:

Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжих ажлын худалдан авах ажиллагаанд аудитыг гүйцэтгэхэд нийт 488,812.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

Баянхошууны автобусны эцсийн буудлын барилгын засвар /Сонгинохайрхан дүүрэг, 9 дүгээр хороо/ Багц-1-т шалгарсан Босго толгой ХХК, Шархадны автобусны эцсийн буудлын барилгын засвар /Баянзүрх дүүрэг, 9 дүгээр хороо/ Багц-4-т шалгарсан Эрхэс Импекс ХХК-иудын ТББ-т ирүүлсэн татварын тодорхойлолтод заасан борлуулалтын орлогын хэмжээ засвартай.

Нийт 93,300.0 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй Хан-Уул дүүргийн Соёлын ордны номын уншлагын жишиг танхимын тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж /Багц-3/-т шалгарсан Харцагат уул ХХК-ийн ТББ-т ирүүлсэн ижил төстэй ажил нь автомашин нийлүүлэлт байсан. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 16.Техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх 16.1.2."сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт;" Үнэлгээний хороо нь ТББ-ийн ТӨӨЗ 18.2 (б)-д "ижил төстэй ажилд тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн туршлагыг тооцно" гэж заасан.

"Ерөнхий боловсролын ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах зориулалтын орчин бүрдүүлэх", "Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй сургууль, цэцэрлэгт жишиг ариун цэврийн байгууламж барих" ажлуудын ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлийн 26.2-т алданги ногдуулах дээд хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна гэж бусад худалдан авах ажиллагааны ТББ-ээс ялгаатай хувь хэмжээ заасан.

Тендерт оролцогч шалгарсан, шалгараагүй байгууллагуудын тендерт цахимаар бүрдүүлсэн материалыг архивлаагүй байна.

Үнэлгээний хороо тендерт оролцогч байгууллагын дотоодын давуу эрхийн зөрүү тооцох асуудлыг хэлэлцээгүй бөгөөд энэ тухай гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний тайлан, дүгнэлтэд тусгаагүй байна.

Нийт 238,710.0 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй тендерийн баримтыг хянаж, багц тус бүрд ижил шалгуур тавьсан боловч үнэлэхдээ өөр өөрөөр үнэлсэн

нь өрсөлдөх тэгш боломжтой, хариуцлагатай байх зарчмыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Нийт 21,200.0 мянган төгрөгийн өртөгтэй Амгалан амаржих газрын эмгэг нярайн тасгийн барилгын засварын ажлын үнэлгээний хороо тендерт оролцогч байгууллагаас ирүүлсэн татварын тодорхойлолтыг шалгаагүй байна.

3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх зорилтын хүрээнд:

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд тус газарт хөрөнгө оруулалтын ажил байгаагүй, батлагдсан төсвийг төлөвлөснөөс хэтрүүлж зарцуулаагүй байна.

Харин сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өглөгтэй гарсан асуудал илэрлээ.

1. ТАНИЛЦУУЛГА

НХААГ нь 2012 оны Засгийн газрын 190 дүгээр тогтоолыг үндэслэн НЗД-ын А/20 дугаар захирамжийн дагуу 2013 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр 5 хэлтэс, 56 албан хаагчийн орон тоотойгоор байгуулагджээ. НЗД-ын 2016 оны А/635 дугаар захирамжаар 4 хэлтэс, 35 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан ба А/752 дугаар захирамжаар газрын дүрэм шинэчлэгдэн үйл ажиллагаагаа явуулж байна. Газрын дүрэмд НХААГ нь 16 чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ.

НЗД-ын 2016 оны Б/146 дугаар захирамжаар Э.Болормааг даргаар, 2018 оны Б/39 дүгээр захирамжаар Б.Гүндсамбууг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр, 2019 оны Б/76 дугаар захирамжаар Э.Болормааг даргаар эргүүлэн тус тус томилсон байна.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж "Зөрчилгүй" санал дүгнэлт хүргүүлжээ.

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 65.1.2, МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль, түүнийг даган гарсан журам, эрх зүйн актууд болон НИТХ-ын Төсөв батлах тухай 2017 оны 02/22, 2018 оны 4/13 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн нийслэл хотод хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг.

Тус газар нь 2018 онд нийт 95,431,418.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 188 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 94.3 хувь, 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 226,059,928.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 215 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 70.9 хувийн хэрэгжилттэй байна.

Тус байгууллага нь 5664225 улсын бүртгэлийн дугаартай, Төрийн сан банканд төсвийн харилцахын үндсэн 100200051015 данстай ба нэгдүгээр гарын үсгийг НХААГ-ын дарга Э.Болормаа 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл, 03 дугаар сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 31-нийг дуусталх хугацаанд Б.Гүндсамбуу, хоёрдугаар гарын үсгийг З.Отгонбат нар тус тус зурж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулжээ.

2. АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1. АУДИТЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

НХААГ-ын 2018 оны үйл ажиллагаа хууль, тогтоомж, нийслэлийн Засаг даргын баталсан захирамж, холбогдох журам, заавар, шийдвэртэй нийцэж буй эсэхэд дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Аудитын удирдамжийн зорилгыг хангахад дараах зорилтуудыг хэрэгжүүллээ. Үүнд:

1. Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх;
2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжсэн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хууль, тогтоомжийн нийцэл хангасан байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;
3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх.

2.2. АУДИТЫН ЦАР ХҮРЭЭ

Дотоод аудит, хяналт шалгалтыг дотоод аудитын олон улсын стандартын дагуу байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудаас лавлагаа, тодруулга, ярилцлага авах, түүвэрлэх, тулган баталгаажуулах, дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болох нотлох баримт, мэдээ мэдээлэл, судалгааг гаргуулан гүйцэтгэв. Тухайлбал:

- ❖ НЗД-ын 2016 оны А/752 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрэм;
- ❖ Газар, хэлтсийн үйл ажиллагааны тайлан, түүний биелэлт;
- ❖ Албан хаагчдын үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ болон ажлын байрны тодорхойлолтууд;
- ❖ Хөдөлмөрийн дотоод журам;
- ❖ 2018 оны санхүүгийн тайлан, баланс;
- ❖ Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангууд, бусад холбогдох материалууд.

Аудитын тайлан дахь тоон дүн мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн болно.

Аудитад хамрах хүрээний хязгаарлалт:

- Албан хаагчдын ажлын байрны зураг авалтыг хамруулаагүй болно.
- Сангийн яам болон Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт гаргасан гомдлын дагуу шалгагдсан худалдан авах ажиллагааг аудитад хамруулаагүй.

3. АУДИТЫН ҮР ДҮН

3.1. Илэрсэн асуудлууд

Зорилт 3.1.1. Байгууллагын засаглалын үйл явцыг үнэлэн, сайжруулах зөвлөмж өгөх;

Шалгуур:

- Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуулиуд;
- НЗД-ын захирамжийн болон дээд газрын тогтоол шийдвэрүүд;
- Дүрэм, журмаар хүлээсэн эрх үүрэг.

Бодит нөхцөл байдал:

Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар:

Тус газар нь дүрмээр хүлээсэн 16 чиг үүргийг хэрэгжүүлж ажиллажээ. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны тайланд тусгасанаар нийт 24 ажлыг зохион байгуулж, биелэлтийг тайлагнажээ. Хавсралт 1-д дэлгэрэнгүй харуулав.

Даргын зөвлөл, дээд газраас, газрын даргын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар:

Тус газар нь дээд газрын тогтоол шийдвэрийг хугацаанд нь хэрэгжүүлж үр дүнг тайлагнан ажилласан байна. Тухайлбал:

2018 онд тус байгууллагын бүртгэл-хяналтад авсан, хэрэгжилтийг НЗДТГ-т тайлагнах шаардлага бүхий нийт 72 тогтоол шийдвэрийн 239 заалт байх бөгөөд хэрэгжилтийн дундаж үнэлгээг 90.0 гэж үзэн, хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2018 оны 12 дугаар сарын 01/1742 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлж, <http://monitoring.ub.gov.mn> программд оруулжээ.

Хүснэгт 1-д харуулснаар “Бүрэн хэрэгжсэн” буюу 90-100 хувийн үнэлгээтэй 220 заалт, “Хэрэгжих шатанд” буюу 50.0-89.0 хувийн үнэлгээтэй 7 заалт, “Хэрэгжилт хангалтгүй” буюу 30.0 хувийн үнэлгээтэй 12 заалт байна. /Энэхүү 12 заалт нь захиалагч байгууллагаас шалтгаалан хүлээлттэй, зураг төсөв, ажлын даалгавар батлагдаагүй, газрын асуудал шийдээгдээгүй ажлууд байна/

ТОГТООЛ ШИЙДВЭР, ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүснэгт 1

№	Баримт бичгийн нэр	Шийдвэр ийн тоо	Нийт заалт	Хэрэгжилтийн хувь			Биелэлт хувиар
				100 %	70%	30%	
1	УИХ-ын тогтоол	1	1			1	30.0%
2	Ерөнхийлөгчийн зарлиг	1	2	2			100.0%
3	Засгийн газрын тогтоол	4	10	10			100.0%
4	Засгийн газрын албан даалгавар	1	11	11			100.0%

5	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	6	23	23			100.0%
6	НИТХ-ын тогтоол, шийдвэр	1	1	1			100.0%
7	НЗД-ын захирамж /ХАА-тай холбоотой/	34	138	120	7	11	90.6%
8	Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар	24	53	53			100.0%
9	Нийт	72	239	220	7	12	90.0%

Тушаал, шийдвэрийн талаар:

Байгууллагын хэмжээнд А тушаал 135, Б тушаал 197 гарсан байна. 2018 онд 8 албан хаагч шинээр томилогдсоноос сул орон тоонд 4, эхийн чөлөөтэй албан хаагчийн оронд түр томилогдсон 4 байна. 10 албан хаагч чөлөөлөгдсөнөөс сахилгын шийтгэлээр 1, өөрийн хүсэлтээр 2, бусад байгууллага руу шилжсэн 5, түр томилогдон ажиллаж байсан 2 байна.

Үйл ажиллагаатай холбогдсон А тушаалаас үнэлгээний хороо байгуулах 37, үнэлгээний хороонд өөрчлөлт оруулах 40 тушаал тус тус гарсан байна. Тус газрын худалдан авах ажиллагааны хэлтэст 15 албан хаагч ажилладаг бөгөөд аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд 187 үнэлгээний хороонд дарга болон наргийн бичгийн даргаар ажиллажээ. /Хавсралт 2-т харуулав/ Үүнээс АБТ-ын чиг үүрэгт тусгагдаагүй 3 албан хаагчийг үнэлгээний хорооны дарга болон нарийн бичгийн даргаар ажиллуулсан байна. Тухайлбал: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга 5 удаа үнэлгээний хорооны даргаар, угтах үйлчилгээний ажилтан 4, даргын туслах 3 удаа тус тус үнэлгээний хорооны нарийн бичгээр ажиллажээ.

Хавсралт 2-т харуулснаар үнэлгээний хороонд зарим албан хаагчийг жилд 2-6 удаа оруулсан бол заримыг нь 40-50 удаа оруулж, ажлын ачааллыг жигд бус хуваарилсан байна. Үнэлгээний хороонд хамаарах асуудлын талаар дэд зорилт 2-т бичсэн/

Стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар:

Тус газар нь шалгалтын хамрах хугацаанд НХААГ-ын даргын 2018 оны 04 дүгээр сарын А/36 дугаар тушаалаар байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг өөрчлөн баталж, 10 дугаар сарын А/119 тушаалын хавсралтаар НХААГ-ын 2018-2020 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг баталжээ.

Гэвч байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн жилийн хүрэх түвшин, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт зэргийг тодорхойлоогүй, 2018 онд хэрэгжилтийг дүгнээгүй байна.

Газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 24 ажлыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа жил жилд хийх үйл ажиллагааг тодорхойлоогүйгээс жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Дотоод хяналтын талаар:

НХААГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын А/145 дугаар тушаалаар “Байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг баталсан бөгөөд тус журмын хүрээнд нийцүүлж газрын даргын 2018 оны 04

дүгээр сарын 05-ны өдрийн А/37 дугаар тушаалаар хяналт, шинжилгээ, үнэлгээний ажлын 2018 оны төлөвлөгөөг баталжээ. Уг төлөвлөгөөг 4 чиглэлээр, 20 ажил гүйцэтгэхээр боловсруулсан байна. Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд төлөвлөгөөний биелэлтийг төлөвлөлтийн дагуу гаргаагүй, зарим хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын давтамж улирал болон сараар хийхээр заасан боловч гүйцэтгэлийг жилээр хийж, төлөвлөгөөт ажлыг бүрэн гүйцэтгээгүй байна.

Газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/78 дугаар тушаалаар "НХААГ-ын 2018 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх" ажлын хэсгийг байгуулж, үр дүнг 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдөрт багтаан танилцуулахыг үүрэг болгосон.

Гэвч тус ажлын хэсгээс 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хяналт, шинжилгээ, үнэлгээний зөвлөмж гаргаж, хэлтсүүдэд 2018 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүргүүлсэн байна.

Газрын дотоод журмын 5.1 "Хууль, хяналтын хэлтэс нь дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллана", 5.2 "Хууль, хяналтын хэлтэс нь бусад хэлтсийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, шалгалтын акт материалыг газрын даргад танилцуулна", 5.3 "Дотоод хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байна" гэж тус тус заасан боловч Хуулийн хэлтсийн 2018 оны жилийн төлөвлөгөөнд дотоод хяналт, шалгалтын талаар ажил тусгаагүй байна. Мөн хуулийн хэлтсийн мэргэжилтний АБТ-ын 4, 5 дах зорилтод "Дотоод хяналт шалгалт, аудит, газрын үйл ажиллагааны чиглэлээр судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт гарган удирдлагад танилцуулах, дотоод хяналт шалгалтын дагуу хийсэн дүгнэлт, зөвлөмжийг газрын даргад цаг тухайд нь танилцуулж ажиллах" гэж заасан боловч хуулийн хэлтсийн мэргэжилтнүүдийн 2018 оны үр дүнгийн гэрээ, түүний биелэлтийн илтгэх хуудсанд энэ талаар тусгаагүй байна.

Газрын даргын 2019 оны 08 дугаар сарын А/135 дугаар тушаалаар батлагдсан албан тушаалын жагсаалтаар хуулийн хэлтэст дотоод аудит хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд дотоод аудит хариуцсан албан хаагч ажиллаагүй.

Дотоод аудит хариуцсан болон хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нь хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахын тулд бусад хэлтэс, нэгжид харьяалагдахгүйгээр газрын даргын шууд удирдлага дор ажиллах шаардлагатай.

Хүний нөөцийн бодлого, нөөцийн хуваарилалт, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, албан хаагчидтай байгуулсан үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээний талаар:

2017 онд 4 жилийн хугацаатай батлагдсан "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийн хүрээнд 9 чиглэлд 45 ажлыг хэрэгжүүлэхээр 2018 оны А/13 дугаар тушаалаар баталж, байгууллагын <http://ub-procurement.mn/> цахим хуудаст нээлттэй байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус байгууллага нь 35 албан хаагчийн орон тоотой ба сул орон тооны мэдээллийг байгууллагын <http://ub-procurement.mn/> цахим хуудаст байршуулж ажиллажээ. Сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр албан бичгээр хүргүүлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудаст байршуулжээ.

АБТ-ын талаар:

Албан хаагч нэг бүрээр АБТ боловсруулж, газрын даргын 2018 оны 03 дугаар сарын А/15 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталжээ. Зарим албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг Хүснэгт 2-т харуулав.

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 2

	Албан тушаалын нэр	Чухал шаардлагатай /туршлага болон боловсрол/
1	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	3-аас доошгүй жил ажилласан байх
2	Хуулийн хэлтсийн дарга	Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан
3	ХАА-ны хэлтсийн дарга	Боловсролын бакалавр, түүнээс дээш зэрэгтэй Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан
4	Мэдээллийн технологийн хэлтсийн дарга	Төрийн албанд ажилласан байх
5	Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан
6	ХАА-ны ахлах мэргэжилтэн	Боловсролын бакалавр, түүнээс дээш зэрэгтэй Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан
7	Мэдээллийн технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан
8	Хуулийн хэлтсийн мэргэжилтэн	Төрийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан
9	ХАА-ны мэргэжилтэн	Дээд боловсролын магистр, түүнээс дээш зэрэгтэй Төрийн албанд 1 жил ажилласан
10	Мэдээллийн технологийн хэлтсийн мэдээллийн технологи, веб хариуцсан мэргэжилтэнгүүд	Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан
11	Мэдээллийн технологийн хэлтсийн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Төрийн албанд 1 жил ажилласан
12	Төлөвлөгөө, тайлан хариуцсан мэргэжилтэн	Тухайн мэргэжлээр 2-оос дээш жил ажилласан
13	Тогтоол, захирамж, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн	Тухайн мэргэжлээр 3-аас дээш жил ажилласан
14	Бичиг хэргийн эрхлэгч	Туршлага харгалзахгүй
15	Архивын ажилтан	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан

Хүснэгт 2-оос харахад АБТ боловсруулж, баталсантай холбоотой дараах асуудлууд байна. Тухайлбал:

- ✓ Хэлтсийн дарга нарын АБТ-ын “туршлага” хэсэгт 4 хэлтсийн даргын ажлын туршлагыг харилцан адилгүй заажээ. Тухайлбал: мэргэжлээрээ ажилласан болон төрийн албанд ажилласан жилийг ялгаатай оруулсан, захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга мэргэжлээрээ болон төрийн албан ажилласан байх эсэх нь ойлгомжгүй, зөвхөн мэдээллийн технологийн хэлтсийн даргыг төрийн албанд ажилласан байх ёстой гэж зааж өгсөн;
- ✓ Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдийн боловсролын зэргийг “Боловсролын бакалавр, түүнээс дээш зэрэгтэй” гэсэн атал ХАА-ны мэргэжилтнийг “Дээд боловсролын магистр, түүнээс дээш зэрэгтэй” гэж заажээ;

- ✓ Мэргэжилтнүүдийн АБТ-ын "Чухал шаардлагатай"-д төрийн албанд болон мэргэжлээр ажилласан жилийг 1 болон 3 жил, адил албан үүрэг гүйцэтгэх албан хаагчдын туршлагыг харилцан адилгүй ялгаатай зааж өгсөн.

НХААГ нь 2018 онд төрийн захиргааны 27 албан хаагч үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний 5 албан хаагч хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж, үр дүнг илтгэх хуудсаар тайлагнан дүгнэсэн байна.

Шалтгаан:

- Хяналт, шинжилгээ үнэлгээний болон дотоод аудит хариуцсан мэргэжилтнүүд захиргаа болон хуулийн хэлтэст харьяалагдаж байгаа нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3.1 "Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд дараах зарчмыг баримтална: 3.1.1. шударга, хараат бус байх", 4.4 "Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ ...", ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 3.2 "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна" заалтуудыг;
- Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд дотоод хяналт сул байгаа нь дээрх журмын 3.1.5 "хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх", газрын дотоод журмын 5.1-5.3 заалтыг;
- Албан тушаалын тодорхойлолтод заагаагүй болон зарим албан хаагчдын ажлын ачааллыг жигд бус хуваарилан үнэлгээний хороонд ажиллуулж байгаа нь албан тушаалын тодорхойлолтын "... санамсаргүй сонголтын аргаар сонгогдож үнэлгээний хороонд ажиллана ..." заалтыг;
- Стратеги төлөвлөгөөний 2018 оны хэрэгжилтийг дүгнээгүй, стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа жил жилийн үйл ажиллагааг тодорхойлоогүйгээс жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаагүй нь тус газрын дотоод журмын 3.2 "Газар нь үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний хүрээнд ажлаа жил ... төлөвлөнө", 3.5 "Газрын үйл ажиллагааны хэтийн болон жилийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн явц, биелэлтэд Захиргаа санхүүгийн хэлтэс хяналт тавина" заалтыг;
- Ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг харилцан адилгүй буюу тухайн албан хаагчид тохируулж тогтоосон нь Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар"-ын 4 "Ажлын байрны тодорхойлолтыг ажил эрхлэгчид тохируулах бус, тухайн байгууллагын зорилт, чиг үүргийг үр ашиг, үр нөлөөтэй хэрэгжүүлэх шаардлагатай нийцүүлэн ажлын байрны шинжилгээ, үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулна" заалтыг **тус тус бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалжээ.**

Үр нөлөө:

- Холбогдох эрх зүйн баримт бичгүүд хэрэгжихгүй байх, дотоод хяналт сулрах нөхцөл үүсэх;
- Байгууллагын хэтийн зорилго алдагдах;
- Ашиг сонирхлын зерчил үүсэх, албан хаагчдын ажлын гүйцэтгэл чанаргүйдэх зэрэг эрсдэлийг үүсгэсэн байна.

Зорилт 3.1.2. Тус газрын нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжсэн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хууль, тогтоомжийн нийцэл хангасан байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

Шалгуур:

- Төсвийн тухай хууль;
- ТБОНӨХБАҮХА тухай хууль, түүнийг даган гарсан журам, эрх зүйн актууд;
- НИТХ тогтоол;
- НЗД-ын захирамж болон дээд газрын тогтоол шийдвэрүүд;
- Бусад эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрүүд.

Бодит нөхцөл байдал:

Нийслэлийн хэмжээнд 2018 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сан, бусад төсвийн эх үүсвэрүүдээр нийтдээ 779,190,969.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1788 /задарсанаар/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар батлагдсанаас 109 төсөл арга хэмжээний захирамж гараагүй, он дамжин санхүүжиж, 1679 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

НИЙСЛЭЛИЙН 2018 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүснэгт 3
/сая.төг.-өөр/

Санхүүжилтийн эх үүсвэр	Зохион байгуулсан төсөл, арга хэмжээ		Үүнээс								Хэрэгжилтийн хувь
			Гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шатандаа яваа		Тендерийн үнэлгээний шатандаа яваа		Тендерийн материал хүлээн авч байгаа		Тендерийн бэлтгэл ажил хийгдэж байгаа		
	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	
Улсын төсөв	143	132,845.6	128	107,236.7	7	12,183.9			8	13,425.0	94.6
Нийслэлийн төсөв	174	125,146.0	168	119,628.0	2	2,200.0	2	318.0	2	3,000.0	98
Нийслэлийн Замын сангийн хөрөнгө	134	40,937.5	130	34,595.6			2	1,490.7	2	4,851.2	90.8
Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан	196	10,257.7	190	10,007.1					6	250.6	97.9
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	504	176,341.2	488	164,230.6	2	2,200.0	4	1,808.7	10	8,101.8	98

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан	199	4,819.2	186	4,482.0					13	337.2	95.4
Дүүргийн төсөв	212	14,685.8	196	12,405.9	3	205.0	1	137.5	12	1,937.4	96
Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт	411	19,505.0	382	16,887.9	3	205.0	1	137.5	25	2,274.6	95.4
Гадаадын зээл тусламжийн хөрөнгө	32	218,062.7	18	137,304.5	9	69,502.3			5	11,256.0	80
Өөрийн хөрөнгө	323	34,988.2	316	34,352.9	1	120.0			6	515.3	98.2
Сангийн хөрөнгө	16	291.4	16	291.4					0	-	100
Урсгал зардал	230	18,591.1	228	18,222.5					2	368.6	99.4
Он дамжих	20	10,335.1	16	7,347.8			1	2,383.0	3	604.3	87
НИЙТ	1679	610,960.2	1592	485,874.2	22	84,211.2	6	4,329.2	59	36,545.6	

**НИЙСЛЭЛД 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ТӨСӨЛ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕРИЙН ЯВЦ**

/ Нийслэлийн 2018 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын тайлангаас/

Хүснэгт 4

Д/д	Тендерийн явц	Ажлын тоо	Ажлын тоо /хувиар/	Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/
1	Гэрээ хийгдсэн	1422	84.6	461,711,953.2
2	Гэрээ хийх зөвлөмж хүргүүлсэн	170	10.1	24,162,292.0
3	Тендерийн үнэлгээ хийж байгаа	22	1.3	84,211,186.8
4	Тендерийн материал хүлээн авч байгаа	6	0.3	4,329,200.0
5	Тендерийн бичиг баримт боловсруулж байгаа	21	1.2	14,631,621.4
6	Зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй ажил	27	1.6	4,264,569.1
7	Газрын асуудал шийдэгдээгүй	6	0.3	11,864,000.0
8	Шийдвэр хүлээж байгаа	5	0.3	5,785,400.0
	Нийт	1679	100	610,960,222.6

Нийслэлийн хэмжээнд 2019 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сан, бусад төсвийн эх үүсвэрүүдээр нийтдээ 611,252,302.2 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1776 /задарсанаар/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

НИЙСЛЭЛИЙН 2019 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүснэгт 5
/сая.төг.-өөр/

Санхүүжилтийн эх үүсвэр	Зохион байгуулсан төсөл, арга хэмжээ		Үүнээс								Хэрэгжилтийн хувь	
			Гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шатандаа яваа		Тендерийн үнэлгээний шатандаа яваа		Тендерийн материал хүлээн авч байгаа		Тендерийн бэлтгэл ажил хийгдэж байгаа			
	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг		

Улсын төсөв	192	243,784.6	92	62,064.4	28	35,136.1	30	39,420.2	42	107,164.0	72.5
Нийслэлийн төсөв	354	174,614.2	93	101,701.2	62	34,987.4	92	18,728.3	107	19,197.3	60.1
Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан	225	16,576.3	9	871.8	25	2,312.6	26	2,697.8	165	10,694.1	40
Нийслэлийн Замын сангийн хөрөнгө	58	38,948.1	23	16,777.5	1	171.5	5	3,582.5	29	18,416.6	60.2
Нийслэлийн төсвийн ХО	829	230,138.6	217	119,350.5	116	37,471.5	153	25,008.6	343	48,308.0	53.1
Дүүргийн төсөв	229	22,641.3	122	10,343.4	23	1,379.2	26	4,664.0	58	6,254.7	91.6
Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан	105	6,256.1	63	2,931.7	21	2,006.7	6	643.6	15	674.1	42
Дүүргийн төсвийн ХО	334	28,897.4	185	13,275.0	44	3,385.9	32	5,307.6	73	6,928.8	76
Сангийн хөрөнгө	4	201.8	4	201.8							100
Өөрийн хөрөнгө	399	45,033.4	317	39,546.0	57	3,847.8	10	601.8	15	1,037.8	92
Он дамжин	64	48,624.6	36	22,670.8	15	3,536.5	2	8,680.0	11	13,737.2	79.4
Гадаадын зээл тусламжийн хөрөнгө	2	4,687.1			1	192.3	1	4,494.8			60
Урсгал зардал	144	9,884.9	88	5,431.5	24	2,344.2	5	837.0	27	1,272.3	80.1
Нийт	1776	611,252.3	847	262,540.0	257	85,914.3	203	84,350.0	469	178,448.0	

НИЙСЛЭЛД 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕРИЙН ЯВЦ

/Нийслэлийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын хагас жилийн тайлангаас/

Хүснэгт 6

Д/д	Тендерийн явц	Ажлын тоо	Ажлын тоо /хувиар/	Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/
1	Гэрээ хийсэн	727	41.0	151,270,928.7
2	Гэрээ хийх зөвлөмж хүргүүлсэн	120	7.0	111,269,068.8
3	Тендерийн үнэлгээ хийж байгаа	257	14.0	85,914,319.1
4	Тендерийн материал хүлээн авч байгаа	203	12.0	84,349,956.7
5	Тендерийн бичиг баримт боловсруулж байгаа	199	11.0	29,961,333.4
6	Зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй ажил	127	7.0	27,225,868.7
7	Газрын асуудал шийдэгдээгүй	15	1.0	42,596,000.0
8	Шийдвэр хүлээж байгаа	128	7.0	78,664,826.7
	Нийт	1776	100	611,252,302.1

НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙГАА ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүснэгт 7

Д/д	Байгууллагын нэр	2018 он		2019 оны 2 дугаар улирал	
		Тоо хэмжээ	Эзлэх хувь	Тоо хэмжээ	Эзлэх хувь
1	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	188	11.2	215	12.1

2	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	294	17.5	283	15.9
3	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар	138	8.2	51	2.8
4	Ус сувгийн удирдах газар	150	8.9	228	12.8
5	Бусад төрийн байгууллага	909	54.1	999	56.2
Нийт		1679	100	1776	100

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд нийслэл, дүүргийн харьяа 35 байгууллага нийт 176,341,159.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 504 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 98.0 хувь, 2019 оны эхний хагас жилд нийслэл, дүүргийн харьяа 28 байгууллага нийт 230,138,570.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 637 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж 53.1 хувийн тус тус хэрэгжилттэй байна. /Хавсралт № 3/

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь 2018 онд 431,418.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 188 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулж 94.3 хувийн хэрэгжилттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

НХААГ-ЫН 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүснэгт 8
/мян.төг.-өөр/

Д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шатандаа		Тендерийн үнэлгээ хийж байгаа		Тендер зарлаагүй		Тендерийн материал хүлээн авч байгаа		Нийт	
		Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв
1	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан	16	1,047,723.26			3	123,919.51			19	1,171,642.77
2	Нийслэлийн төсөв	50	6,894,893.17	1	400,000.00	1	2,300,000.00	2	318,000.00	54	9,912,893.17
3	Он дамжих	9	2,783,300.00			2	418,369.00	1	2,383,000.00	12	5,584,669.00
4	Улсын төсөв	95	67,946,785.27	2	175,427.92	6	10,640,000.00			103	78,762,213.19
НИЙТ		170	78,672,701.70	3	575,427.92	12	13,482,288.51	3	2,701,000.00	188	95,431,418.13

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь 2019 онд 226,145,628.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 215 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулж 70.9 хувийн хэрэгжилттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

НХААГ-ЫН 2018 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Хүснэгт 9
/мян.төг.-өөр/

Д/д	Санхүүжилтийн эх үүсвэр	Гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шатандаа		Тендер зарлаагүй		Тендерийн материал хүлээн авч байгаа		Тендерийн үнэлгээ хийж байгаа		Нийт	
		Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв	Тоо	Батлагдсан төсөв
1	Урсгал зардал							1	174,069.8	1	174,069.8
2	Улсын төсөв	66	31,732,659.9	20	58,570,000.0	10	10,551,150.0	12	20,329,500.0	108	121,183,309.9
3	Он дамжин	13	1,958,448.5	1	300,000.0	1	31,500.0			15	2,289,948.5
4	Нийслэлийн төсөв	15	61,486,400.0	19	6,915,600.0	12	2,096,600.0	17	27,185,500.0	63	97,684,100.0

5	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан	2	132,600.0	13	854,600.0	4	307,000.0	8	1,320,000.0	27	2,614,200.0
6	Нийслэлийн Замын сангийн хөрөнгө					1	2,200,000.0			1	2,200,000.0
Нийт		96	95,310,108.4	53	66,640,200.0	28	15,186,250.0	38	49,009,069.8	215	226,145,628.1

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь 2018 онд нийт 53 төсөл арга хэмжээ, 2019 оны эхний хагас жилд гэрээ байгуулсан болон гэрээ байгуулах шатандаа яваа 13 төсөл арга хэмжээ нийт 66 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Аудитын баг үүнээс 40 төсөл арга хэмжээ буюу 66.7 хувийг түүвэрт хамруулан аудит гүйцэтгэхэд 16 төсөл арга хэмжээнд нийт 488,812.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. Баянхошууны автобусны эцсийн буудлын барилгын засвар /Сонгинохайрхан дүүрэг, 9 дүгээр хороо/ Багц-1-т шалгарсан Босго толгой ХХК-ийн ТББ-т ирүүлсэн татварын тодорхойлолтод борлуулалтын орлогын хэмжээ засвартай.

Тендерийн баримт бичигт ирүүлсэн нь:

Борлуулалтын орлого		(Төгрөгөөр)
Он	Борлуулалтын орлогын хэмжээ	
2015		3 474 875.00
2016		0.00
2017		0.00
Нийт		3 474 875.00

Татварын ерөнхий газрын цахим хуудаснаас:

Борлуулалтын орлого		(Төгрөгөөр)
Он	Борлуулалтын орлогын хэмжээ	
2015		3 474 875.00
2016		0.00
2017		0.00
Нийт		3 474 875.00

2. Шархадны автобусны эцсийн буудлын барилгын засвар /Баянзүрх дүүрэг, 9 дүгээр хороо/ Багц-4-т шалгарсан Эрхэс Импекс ХХК-ийн ТББ-т ирүүлсэн татварын тодорхойлолтод борлуулалтын орлогын хэмжээ засвартай.

Тендерийн баримт бичигт ирүүлсэн нь:

Борлуулалтын орлого		(Төгрөгөөр)
Он	Борлуулалтын орлогын хэмжээ	
2015		20 400 000.00
2016		11 200 000.00
2017		20 400 000.00
Нийт		52 000 000.00

Татварын ерөнхий газрын цахим хуудаснаас:

Он	Борлуулалтын орлогын хэмжээ	Төгрөгөөр
2015		29 500 500.00
2016		11 206 227.39
2017		5 900 018.00
Нийт		46 606 745.39

3. Нийт 93,300.0 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй Хан-Уул дүүргийн Соёлын ордны номын уншлагын жишиг танхимын тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж /Багц-3/-т шалгарсан Харцагат уул ХХК-ийн ТББ-т ирүүлсэн ижил төстэй ажил нь Автомашин нийлүүлсэн ажил байсан. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн **16.Техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх 16.1.2."сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт;** Үнэлгээний хороо нь ТББ-ийн ТӨӨЗ 18.2 (б)-д **"ижил төстэй ажилд тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлсэн туршлагыг тооцно"** гэж заасан.
4. "Ерөнхий боловсролын ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах зориулалтын орчин бүрдүүлэх", "Усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй сургууль, цэцэрлэгт жишиг ариун цэврийн байгууламж барих" ажлуудын ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлийн 26.2-т алданги ногдуулах дээд хэмжээ хоногт гэрээний үнийн 0.05 хувь байна гэж бусад худалдан авах ажиллагааны ТББ-ээс ялгаатай хувь хэмжээ заасан.
5. Сонгинохайрхан дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн 5 багц ажлын тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд:
 - Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас тендер нээсэн өдрийн байдлаар татварын өр төлбөрийн талаар мэдээллийг шалгана.
 - Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сангаас тендер оролцогчдын сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.
 - Тендерийн баталгааг гаргагч арилжааны банкнаас цахим системээр тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн байна гэж тус тус тусгасан байна.

Тендерт оролцогч шалгарсан, шалгараагүй байгууллагуудын тендерт бүрдүүлсэн материалыг тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгттэй тулган шалгахад татварын өр төлбөртэй эсэх, борлуулалтын орлогын хэмжээ, тендерийн баталгааг цаасаар архивлаагүйгээс шалгах боломжгүй байна.

Тиймээс татварын өртэй, борлуулалтын орлогын хэмжээ шаардлагад хүрэхгүй байх, тендерийн баталгааг ирүүлсэн эсэх, хугацаа болон хэмжээ нь зөв эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.

6. Сонгинохайрхан дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн засварын Багц 1 50,831.6 мянган төгрөг, Багц 2 44,193.3 мянган төгрөг, Багц 5 40,577.9 мянган төгрөг, нийт 135,602.80 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаанд Босго толгой ХХК нь ирүүлсэн тендерийн баримтад 2018 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 55/18

дугаар албан бичгээр дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах хүсэлт гаргаж Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 1307 дугаар албан бичгийг хавсаргасан байна.

Гэтэл НХААГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/62 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо нь тендерийг үнэлэхдээ Босго толгой ХХК-д дотоодын давуу эрхийн зөрүү тооцох эсэх тухай хэлэлцээгүй бөгөөд энэ тухай гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний тайлан, дүгнэлтэнд тусгаагүй байна.

7. Нийт 238,710.0 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй тендерийн баримтыг хянаж, багц тус бүрд ижил шалгуур тавьсан боловч үнэлэхдээ өөр өөрөөр үнэлсэн нь өрсөлдөх тэгш боломжтой, хариуцлагатай байх зарчмыг тус тус хэрэгжүүлэхгүй байна.

Тус тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд зураг төсвийн үнэ 2,000.0 сая төгрөгийг хяналтын төсөвт тусгаснаар тооцож ирүүлнэ гэж заасан. Тендерт оролцогч байгууллагуудын ирүүлсэн материалыг шалгахад Тэнхлэг констракшн ХХК, СММС ХХК, Босго толгой ХХК-иуд тооцож ирүүлсэн бол, харин Нью пристиж констракшн ХХК, Эрхэс импекс ХХК тооцож ирүүлээгүй байна.

Гэтэл НХААГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/62 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар Багц -1 ийг хэлэлцэхдээ Эрхэс импекс ХХК, СММС ХХК, Босго толгой ХХК-иудыг зураг төсвийн үнийг хяналтын төсөвт тусгасанаар тооцож ирүүлээгүй тул шаардлагад нийцэхгүй гэсэн дүгнэлт гаргасан. Харин Тэнхлэг констракшн ХХК, Нью пристиж констракшн ХХК-иуд шаардлагад нийцэж байна гэж үнэлээд хамгийн бага үнийн саналтай Нью пристиж констракшн ХХК-ийг шалгаруулсан байна.

Багц 3 дээр Сүмбэр сүлд ХХК нь зураг төсвийн үнийг тооцож ирүүлээгүй нь шаардлагад нийцээгүй гэсэн дүгнэлт гаргаж Тэнхлэг констракшн ХХК-ыг шалгаруулсан байна.

Мөн Багц 4 дээр байгууллагууд бүгд зураг төсвийн үнийг хяналтын төсөвт тусгаснаар ирүүлээгүй байна.

8. Нийт 21,200.0 мянган төгрөгийн өртөгтэй Амгалан амаржих газрын эмгэг нярайн тасгийн барилгын засварын ажлын үнэлгээний хороо тендерт оролцогч байгууллагаас ирүүлсэн татварын тодорхойлолтыг шалгаагүй байна.

ТББ-ийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэнд ТООЗ 1.1

- Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолтыг үнийн саналын баримт бичигт ирүүлэх ба ингэхдээ хуудасны доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ гэж тус тус баталжээ.

Тендерт шалгарсан "Мөнхтулга Уянга" ХХК-ийн татварын тодорхойлолтыг тоо тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаараар Татварын ерөнхий газрын цахим хуудсаар шалгахад дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ 525,780.50 төгрөгийн татварын илүү төлөлттэй, ААНОАТ-т 568,702.30 төгрөг, Суутган-1 288,972.00 төгрөг, нийт 857,674.30 төгрөгийн татварын өртэй байна.

Шалтгаан:

- Үнэлгээний хорооны гишүүд ТББ-ийн ТООЗ 5.3 (а)-т борлуулалтын орлогын хэмжээ нь “Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.” гэж заасны дагуу тендерт оролцогч байгууллагууд нь орлогын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор татварын албаны тодорхойлолтыг засварлан, орлогыг нэмэгдүүлж ирүүлсэнийг тулган баталгаажуулж, хянаагүй;
- УБ хотын нийтийн төв номын сангийн салбаруудад тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил 3 багц ажил 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зарласаны 3 дугаар багц буюу Хан-Уул дүүргийн Соёлын ордны номын уншлагын жишиг танхимын тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх багцад нэг ч байгууллага материал ирүүлээгүй учраас 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдөр дахин зарлаж, нэг байгууллага үнийн санал ирүүлсэнийг тухайн худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах зорилгоор шалгаруулсан;
- Үнэлгээний хороо нь ижил төстэй төсөл арга хэмжээний ТББ-г боловсруулахдаа алдангийн хувь хэмжээг адил заагаагүй;
- Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга тендерийн материалыг архивлахдаа цахимаар шалгасан баримтыг хэвлэж архивлаагүй;
- Үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалыг мөрдөж ажиллаагүйгээс;
- Үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХА тухай хууль, журам, хяналтын төсвийн дагуу батлагдсан ТББ-ийг үндэслэн тендерт оролцогч байгууллагаас ирүүлсэн баримтыг хянаж үнэлээгүйгээс тус тус шалтгаалжээ.

Үр нөлөө:

- Тендерт оролцогч компаниуд дараагийн худалдан авах ажиллагаанд оролцохдоо хуурамч, засвартай, хууль бус бичиг баримт ирүүлж хэвших;
- Тухайн ажлыг хийх ажлын туршлагагүй байгууллага шалгарч, төсөл, хөтөлбөрийн үр өгөөж буурах, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах;
- Алдангийн хэмжээг ялгаатай тооцсоноор аж ахуйн нэгжүүдэд өрсөлдөх тэгш боломжтой байх зарчим алдагдах;
- Тендерт оролцогч байгууллагуудын татварын өртэй, борлуулалтын орлогын хэмжээ шаардлагад хүрэхгүй байх, тендерийн баталгааг ирүүлсэн эсэх, хугацаа болон хэмжээ нь зөв эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй;
- Үнэлгээний хороо тендерт оролцогч байгууллагыг үнэлэхдээ дотоодын давуу эрх тооцоогүйгээс тендер шалгаруулалтын үйл ажиллагаа үр ашигтай, хэмнэлттэй байх зарчим, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлого алдагдах;
- ТБОНӨХБАҮХА тухай хууль, журам, худалдан авах ажиллагааны зарчим хэрэгжихгүй байх үр нөлөөг тус тус үүсгэж байна.

Зорилт 3.1.3. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд дүгнэлт, зөвлөмж өгөх.

Шалгуур:

- ТБОНӨТ, ТБОНӨХБАҮХАТ, НББ-ийн тухай болон холбогдох хуулиуд;
- Холбогдох дүрэм, журмууд.

Бодит нөхцөл байдал:

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтын ажил байгаагүй.

2018 оны санхүүгийн үйл ажиллагааны талаар:

2018 онд үйл ажиллагааны зардалд 496,421.6 мянган төгрөг баталснаас 444,724.9 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 51,696.6 мянган төгрөгийг хэмнэжээ. Үндсэн үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 26,166.0 мянган төгрөгийг бүрдүүлж ажиллажээ.

Бүтцийг харуулбал:

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН 2018 ОН

Хүснэгт 10

Дд	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	496,421.60	444,724.90	51,696.70
2	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	372,298.00	324,796.30	47,501.70
3	Үндсэн цалин	346,041.00	298,539.30	47,501.70
4	Унаа хоолны хөнгөлөлт	26,257.00	26,257.00	-
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөгдөх шимтгэл	44,675.80	40,487.40	4,188.40
6	Хангамж бараа материалын зардал	27,672.80	27,670.40	2.40
7	Бичиг хэрэг	7,636.80	10,383.60	(2,746.80)
8	Тээвэр шатахуун	5,280.00	5,468.30	(188.30)
9	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,756.00	11,818.50	2,937.50
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,775.00	39,774.60	0.40
11	Төвлөрүүлэх шилжүүлэг			-
12	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000.00	6,999.90	0.10
13	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	5,000.00	4,996.00	4.00
14	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000.00	26,166.00	6,166.00

Нийт зардлын 82.0 орчим хувийг албан хаагчдын цалин, унаа хоолны хөнгөлөлт, НДШ, 9.0 орчим хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж

/үнэлгээний хорооны гишүүдийн урамшуулал, байрны ашиглалтын зардал/, 6.0 орчим хувийг хангамж бараа материалын зардал эзэлж байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу цахим тендерээс 26,166.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд зардлыг төлөвлөснөөс хэтрүүлж зарцуулаагүй байна. Тайлант онд 35 албан хаагч ажиллахаас 33 албан хаагч ажиллаж цалингийн зардал хэмнэжээ.

Албан хаагчдын цалингаас суутгасан гүйлгээг Төрийн сан хянаагүйгээс Тайвань байк ХХК-д 571.4 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Сахилгын шийтгэлийг 2018 онд 7 албан хаагчид ногдуулсан бөгөөд сахилгын шийтгэлтэй, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй 6 албан хаагчид 3,012.9 мянган төгрөгийн урамшуулал 2018 оны А/67, А/86 дугаар тушаалуудаар олгожээ. Үүнд:

**САХИЛГЫН ШИЙТГЭЛТЭЙ АЛБАН
ХААГЧДАД ОЛГОСОН УРАМШУУЛАЛ**

Хүснэгт 11

Дд	Албан хагчийн нэрс	Албан тушаал	Олгосон урамшуулал
1	Ц.Сэргэлэн	ХАА хариуцсан мэргэжилтэн	716.3
2	Г.Тэмүүжин	ХАА хариуцсан мэргэжилтэн	516.4
3	Л.Одхүү	ХАА хариуцсан мэргэжилтэн	479.3
4	Н.Оюунбадрах	ХАА хариуцсан мэргэжилтэн	479.3
5	О.Ганболд	ХАА хариуцсан мэргэжилтэн	342.0
6	Б.Баярмагнай	Хуулийн мэргэжилтэн	479.3
Нийт			3,012.9

Үндсэн хөрөнгийн талаар:

НХААГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд биет хөрөнгө 29,961.5 мянган төгрөг, биет бус хөрөнгө 1,039.2 мянган төгрөг, нийт 31,000.7 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй эргэлтийн бус хөрөнгө тайлагнажээ. Үүнд:

ҮНДСЭН ХӨРӨНГӨ 2018 ОН

Хүснэгт 12

	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Тоног төхөөрөмж	7,650.8	-	2,409.3	5,241.5
Тавилга хэрэгсэл	25,100.0	-	380.0	24,720.0
Биет бус хөрөнгө	1,039.2	-		1,039.2
Нийт дүн	33,790.0	-	2,789.3	31,000.7

2018 онд хөрөнгө нэмэгдээгүй, худалдан авалт хийгээгүй байна. Харин байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрийн дагуу НӨХГ-ын даргын 2018 оны А/380, А/50 дугаар тушаалаар 467.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 2,321.8 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээс хассан байна.

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд хөрөнгийн тооллогыг хагас жил /А83/ болон жилийн эцсээр /А/132/ хийж, үр дүнг илтгэх хуудсаар баталгаажуулжээ. Тус тооллогоор дутсан хөрөнгө гараагүй байна.

Бараа материалын талаар:

НХААГ-ын 2018 оны санхүүгийн тайланд оны эхэнд бараа материал 21,221.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 22,101.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 24,141.4 мянган төгрөгийн бараа материал зарлагдаж, 19,182.3 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан байна. Үүнд:

БАРАА МАТЕРИАЛ Хүснэгт 13

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Бичиг хэргийн материал	11,122.4	8,544.4	10,599.3	9,067.5
Аж ахуйн материал	9,629.3	617.6	1,907.6	8,339.3
БҮТЭЭ	470.0	12,939.8	11,634.4	1,775.4
Нийт	21,221.8	22,101.9	24,141.4	19,182.3

Бараа материалын зарлагыг тухай бүр шаардах хуудсаар зарлагаджээ. Бараа материалын зардлын 44.0 орчим хувийг бичиг хэргийн материал, 48.0 орчим хувийг БҮТЭЭ эзэлж байна.

Шалтгаан:

- Сахилгын шийтгэлтэй албан хаагчдад урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл.Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.4.1 *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, НИТХТ-ийн 2014 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн байгууллага ... ажиллагсдад үр дүнгийн шагнал, урамшуулал олгох журам"-ын 3.4.2 *"тухайн жилд сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд урамшуулал олгохгүй"* заалтуудыг;
- Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өглөгтэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.4.8 *"төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"* заалтыг тус тус **бүрэн хэрэгжүүлээгүйгээс шалтгаалжээ.**

Үр нөлөө:

- Үр ашиггүй зардлыг санхүүжүүлэх;
- Төсвийг зориулалт бусаар зарцуулах **эрсдэлийг үүсгэсэн байна.**

3.2 ДҮГНЭЛТ

Аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд байгууллагын дотоод хяналт сул, хяналт, шинжилгээ үнэлгээний мэргэжилтнээс өөр дотоод хяналтын ажилтангүй ажиллажээ.

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байгаа хэдий ч стратеги төлөвлөгөөг хангалттай сайн боловсруулаагүйн улмаас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаагүй байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулах, тендер зохион байгуулах хугацааг зөв тооцоолох шаардлагатай.

Мөн албан тушаалын тодорхойлолтод заагаагүй болон зарим албан хаагчдын ажлын ачааллыг жигд бус хуваарилж үнэлгээний хороонд ажиллуулсан байдлыг цаашид давтан гаргахгүй байх, санамсаргүй сонголтын аргаар үнэлгээний хороонд ажиллах албан хаагчийг сонгож ажиллуулах тал дээр онцгой анхаарах шаардлагатай.

Төсөв санхүүгийн хувьд аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд төсөвлөсөн зардлыг хэтрүүлээгүй байна. Хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд хийж хэвшжээ.

Тус газар нь ижил төстэй ажлын тендерийн баримт бичигт хүний нөөцийн чадавхийг ялгаатай заадаг /Инженер техникийн ажилтнуудын 50 хувь нь тухайн байгууллагын үндсэн ажилтнууд байна, Ерөнхий инженер, барилгын инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнууд нь үндсэн ажилтан байна/, тендерт оролцогч байгууллагууд инженерийн техникийн ажилтны ажлын туршлагыг баталгаажуулах нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох бичилттэй /даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн баталгаажуулалт/ хуудсыг дутуу ирүүлсэн, ирүүлээгүй зөрчил нийтлэг байна.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд нийт 504 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсанаас нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар 73, нийслэлийн Авто замын хөгжлийн газар 124, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 152 төсөл, арга хэмжээ, 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 637 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсанаас нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар 91, нийслэлийн Авто замын хөгжлийн газар 36, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба 253 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тус тус зохион байгуулжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт №3/





Тус газар нь дүрмээр хүлээсэн "Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хуулийн дагуу зохион байгуулах;" үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий НЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг байтал тус чиг үүргээс өөр чиг үүрэг бүхий байгууллагуудад худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлсэн байна.

3.3 ЗӨВЛӨМЖ

- ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, шат шатанд тавих дотоод хяналт, шалгалтыг сайжруулах;
- Үнэлгээний хороонд ажиллах албан хаагчдыг санамсаргүй сонголтын аргаар сонгох, давтан гаргахгүй байх, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлж ажиллах;
- ЗГ-ын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-д нийцүүлэн байгууллагын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах;
- Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйл.Төрийн албаны зарчим 7.1.5 "төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах" зарчмын дагуу боловсруулах, давтан гаргахгүй байх;
- Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 3-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор батлагдсан "Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам"-ыг хэрэгжүүлэх, тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг тулган баталгаажуулж байх, татварын өртэй эсэхийг хянах;
- ТББ-т заасан шалгуурын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах;
- ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлийн алдангийн хэмжээг ижил хувь хэмжээтэй болгох;

- Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга ТБОНӨХБАУХА тухай хуулийн 49.2.5, 49.2.9 дахь заалтыг мөрдөж татварын тодорхойлолт, санхүүгийн тайлан, тендерийн баталгааг цахим системээр шалгахдаа цаасаар хэвлэн архивлах;
- Үнэлгээний хороо дотоодын давуу эрхийн зөрүү тооцуулах хүсэлтийг ТБОНӨХБАУХА тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалын дагуу хэлэлцэн шийдвэрлэх;
- Үнэлгээний хороо тендерийг хянаж, үнэлэхдээ ТБОНӨХБАУХА тухай хуулийн 27. Тендерийг хянан үзэх, 28. Тендерийг үнэлэх зүйлүүд, хяналтын төсвийг баримталж батлагдсан ТББ-ийн дагуу тендерт оролцогч байгууллагуудаас ирүүлсэн материалыг хянан үнэлэх.
- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", НИТХТ-дийн 2014 оны 220 дугаар тогтоолоор баталсан "Нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн байгууллага ... ажиллагсад үр дүнгийн шагнал, урамшуулал олгох журам"-ын 3.4.2 "тухайн жилд сахилгын шийтгэл оногдуулсан ажилтанд урамшуулал олгохгүй" заалтуудыг мөрдөх;
- Төсвийг зохистой удирдан өглөг үүсгэхгүй байх, давтан гаргахгүй байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах.

Илэрсэн асуудал бүрээр өгсөн зөвлөмжийн хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүний биелэлтийг нийслэлийн Дотоод аудитын газарт хугацаандаа ирүүлэхийг мэдэгдэж байна.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Я.САРАНСҮХ

ХЯНАСАН:

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.БАТЗОРИГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /АХЛАХ АУДИТОР /СХШУАБ/

Н.НАРАНЧИМЭГ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН /АУДИТОР/

Б.ОТГОНЦЭРЭН

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН /АУДИТОР/

Б.БАЯРМАА

Дд	Дүрмээр хүлээсэн чиг үүргүүд	Хийсэн ажлууд
1	<p>3.1.1.Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн хуулийн дагуу зохион байгуулах;</p>	<p>НЗД-аас баталсан “Худалдан авах ажиллагааны 2018 оны ерөнхий төлөвлөгөө”-г төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)—д, мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу “Монголын үнэн” сонины 2018 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн дугаарт нийтлүүлж олон нийтэд мэдээлж ажиллажээ. Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж сонгон шалгаруулалтын ил тод, нээлттэй байдлыг хангасан ажлын үр дүн нийслэлийн хэмжээнд 58,3 хувьд хүрч өнгөрсөн оныхоос 25,3 хувиар өссөн үзүүлэлт гарсан байна. Тус газарт эрх шилжиж ирсэн нийт 188 ажлаас 178 ажлын худалдан авах ажиллагааг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, байгууллагын www.ub-procurement.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг тухай бүр нийтэлж ажилласан байна. НЗД-ын 2018 оны А/268 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн шилэн тендерийн бүртгэлийн системийн үйл ажиллагааны журам”-ын дагуу http://open.ulaanbaatar.mn/map/ цахим системд худалдан авах ажиллагааг эрх шилжүүлсэн захирамжийг НЗДТГ-ын БТХ-ээс системд бүртгэж шилжүүлсэн тухай бүрт үнэлгээний хорооны бүрэлдэхүүнээс тендер зохион байгуулалтын талаарх мэдээллийг ил, тод нээлттэй болгож олон нийтэд хүргэжээ.</p>
2	<p>3.1.2. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн жилд хийх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тогтоосон хугацаанд НЗДТГ, Сангийн яаманд хүргүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэж тайлагнах;</p>	<p>Тус газраас ТЕЗ-ийн 2018 онд хэрэгжүүлэх ХАА-ны батлуулсан төлөвлөгөөг 01/4286 дугаар албан бичгээр Монгол улсын Сангийн яаманд хүргүүлжээ. Мөн ТЕЗ-ийн эхний хагас жилд нутгийн захиргааны 35 байгууллагад эрх шилжүүлсэн 1163 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эхний хагас жилийн тайланг 2018 оны 01/692 дугаар албан бичгээр НЗД, НЗДТГ, НДАА, НИТХ-ын ажлын алба болон ТӨБЗГ-т хүргүүлж, НЗД-аар уламжлан 2018 оны 01/2481 дугаар албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлжээ.</p>
3	<p>3.1.3. Тендер зарлахын өмнөх бэлтгэл ажлын хүрээнд төсөл, арга хэмжээний төлөвлөлт хөрөнгө оруулалтын бусад ажлуудтай уялдаж байгаа эсэхийг хянах;</p>	<p>Тендерийн бэлтгэл ажлын хүрээнд төсөл, арга хэмжээний төлөвлөлт, уялдаа холбоог ханган ажиллаж байгаа ба тайлант хугацаанд Нийслэлийн Авто зам хөгжлийн газраас 1, Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газраас 2, Нийслэлийн Боловсролын газраас 4, Нийслэлийн Өмчийн харилцааны газраас 3, Нийслэлийн Соёл урлагийн газраас 7, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 106, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 1, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас 55 төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар болон холбогдох бусад материалыг хүлээн авч худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.</p>
4	<p>3.1.4. Барилга зам, инженерийн шугам сүлжээ зэрэг онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг төсөв батлагдсан даруйд шуурхай зохион байгуулах.</p>	<p>Улирлын шинж чанартай сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, өргөтгөл, тохижилтын 115 төсөл, арга хэмжээний эрх шилжин ирсэн ба захиалагчаас зураг төсөв, холбогдох баримт бичгийг ирүүлсэн 104 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг дунджаар 8 хоногт багтаан эхлүүлсэн байна.</p>

5	3.1.5. Төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулах "Үнэлгээний хороо байгуулах", хорооны бүрэлдэхүүнд олон нийтийн төлөөлөл болох иргэн, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оруулах.	Тус газраас 2016 оны НИТХ-ын 48 дугаар тогтоолоор АЗ гэрчилгээтэй 16 иргэн, НИТХ-ын 2018 оны 79 дугаар тогтоолоор АЗ гэрчилгээтэй 77 иргэнийг тус тус батлуулан үнэлгээний хороонд олон нийтийн төлөөллөөр ажиллах боломжоор хангасан. Эдгээр иргэдээс газрын даргын үнэлгээний хороо байгуулсан 39, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан 8 удаагийн тушаалаар 26 иргэнийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд олон нийтийн төлөөллөөр томилжээ.
6	3.1.6. Захиалагчаас ирүүлсэн зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийн баримт бичгийг хянаж баталгаажуулах ажлыг зохион байгуулах;	Захиалагчаас ирүүлсэн зураг, төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж, Хуулийн хэлтсийн дарга, Худалдан авах ажиллагааны хэлтсийн даргаар хянуулан газрын даргаар батлуулан ажиллажээ. Баталгаажсан тендерийн баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор 162 ширхэг лацаар битүүмжилж, бүртгэл хөтлөн ажиллаж ирсэн байна.
7	3.1.7. Тендерийн урилгыг өдөр тутмын сонин болон байгууллагынхаа цахим хуудсанд тогтоосон хугацаанд байршуулж, тендер шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, дүнг тухай бүр ил тод, нээлттэй мэдээлэх;	Тус газарт НЗД болон бусад байгууллагаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, тендер зарлагдсан улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 178 ажлын урилга, зарыг "Монголын мэдээ" сонин, "Засгийн газрын мэдээ" сонин болон бусад холбогдох мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажиллажээ.
8	3.1.8. Тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах үйл ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу гүйцэтгэх;	Тендер хүлээн авах, нээх, хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулахтай холбоотойгоор хэлтсийн дарга, үнэлгээний хорооны дарга нар үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга, гишүүдийг тухай бүр аргачлалаар хангаж, холбогдох хууль, журам, зааврын дагуу зөвлөмж, чиглэл өгөн ажиллажээ. "Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, тайлагнах, архивлах журам", "Худалдан авах ажиллагаатай холбоотой жишиг баримт бичгүүд"-ийг газрын даргын 2018 оны 05 дугаар сарын А/58 дугаар тушаалаар батласан байна.
9	3.1.9. Худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах;	Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 2017 онд худалдан авах ажиллагааг бүрэн хэрэгжүүлж гэрээ байгуулагдсан 296 ажлын баримтаар цаасан суурьт архивын нэгж үүсгэснээс байнга хадгалах 252, түр хадгалах 44 хадгаламжийн нэгжийг тус тус үүсгэжээ. Цахим захирамжлалын баримтанд нягтлан шалгалт хийх ажлын хүрээнд цахимаар зарлагдсан ажлын тендерт оролцогч аж ахуйн нэгжийн баримт бичгийг 276 хн /CD/-д хуулбарлан хадгалалтын болон хамгаалалтын хувь үүсгэсэн байна.
10	3.1.10. Тухайн жилд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг зохих маягтын дагуу бэлтгэж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Сангийн яаманд хүргүүлэх;	Дүрмээр хүлээсэн үүргийн 3.1.2-т заасны дагуу холбогдох газруудад хүргүүлсэн ба НЗД-ын А/335 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, дүүргийн ХААА-нд хэрэгжүүлж буй худалдан авах ажиллагааг бүртгэн, 2018 оны 01, 02, 04, 06, 07, 08, 09, 10, 11 дүгээр сарын тайланг сар бүр хугацаанд нь 01/109, 01/191, 01/512, 01/861, 01/999, 01/1202, 01/1346, 01/1545, 01/1674 дугаар албан бичгээр тус тус НЗДТГ, ХШҮХ, СТСХ, БТХ, НИТХ-ын ажлын алба, НДАА, ТӨБЗГ-т тус тус хүргүүлсэн байна.

11	3.1.11. Худалдан авах ажиллагааны арга, хэлбэрийг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцсэн стандарт, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	Байгууллагын үндсэн чиг үүрэг буюу худалдан авах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх зорилгоор хэрэгжилтийг КРІ үнэлгээгээр тооцох, аргачлалыг томьёолж, 2016- 2018 оны ажлуудын судалгааг боловсруулж дүгнэлт хийж ажилласан ба КРІ үнэлгээгээр тооцох, аргачлалыг томьёолж 2018 оны 01/54, 01/246 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн байна. Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан "Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журам" сэдэвт сургалтад байгууллагын 15 албан хаагч хамруулжээ.
12	3.1.12. Худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, НЗД-д танилцуулах;	ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэгт заасныг үндэслэн "Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал"-ыг шинэчлэх төсөлд тусгах санал боловсруулан 2018 оны 02/236 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж ажиллажээ. Мөн "ТБОНӨХБАҮХА-г төлөвлөх, тайлагнах журам" болон "Цахим тендер шалгаруулалтын журам"-ыг шинэчлэх төсөлд тусгах саналыг тус тус боловсруулан 2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 01/1544 дугаар албан бичгээр НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлжээ.
13	3.1.13. НЗДТГ-ын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх;	Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль журам, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах тухай 2018 оны 01 дүгээр сарын 02/57 дугаар, 2018 оны 04 дүгээр сарын 01/297 дугаар, 05 дугаар сарын 02/610 дугаар, 10 дугаар сарын 01/1394 дугаар албан бичгээр Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад зөвлөмж хүргүүлжээ. Мөн ТАБЗГ-тай хамтран 2018 оны 01 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын 101 албан хаагчид Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт болон худалдан авах ажиллагааны хууль, журмын талаар сургалт зохион байгуулан явуулсан байна. /Мөн холбогдох мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажиллажээ/
14	3.1.14. Дүүргүүдийн худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, ажлын гүйцэтгэл, цаг үеийн асуудлаар шуурхай үүрэг, даалгавар өгч, түүний биелэлтийг хангуулж ажиллах;	Дүрмээр хүлээсэн үүргийн 3.1.13-т заагдсан ажлуудаас гадна БНД-ийн ХААА-ны 5 албан хаагчид 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр "Зөвлөх үйлчилгээний" тухай сургалт зохион байгуулжээ. Мөн дүүргүүдийн Худалдан авах ажиллагааны албадын тайлан мэдээ хариуцсан албан хаагчдад 2018 оны 03 дугаар сарын 01 болон 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр худалдан авах ажиллагааны тайлан, нэгтгэлийн талаар сургалт мэдээлэл хийж, хамтран ажиллажээ. Газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, албан хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор батлагдсан ажлын хэсэг хуваарийн дагуу 9 дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад томилогдон ажилласан байна.
15	3.1.15. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;	Бусад дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд дурдсан ажлуудыг гүйцэтгэхийн зэрэгцээ Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан "Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журам" сэдэвт сургалтад байгууллагын 15 албан хаагч хамруулжээ.
16	3.1.16. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг;	Хэрэгжүүлж ажиллажээ.

Үнэлгээний хороонд ажилласан тоо *Хавсралт 2*

Дд	Албан хаагчдын нэрс	Даргаар	Нарийн бичгээр	Тайлбар
1	Т.Сэлэнгэ		2	Жилийн турш ажилласан
2	Г.Тэмүүжин	38		Жилийн турш ажилласан
3	Г.Гончигдорж		27	Жилийн турш ажилласан
4	С.Болдбаатар		12	2018 оны 03 сараас ХАА-ны хэлтэст ажилласан
5	Л.Одхүү		50	Жилийн турш ажилласан
6	Н.Оюунбадрах		17	2018 оны 03 сараас ХАА-ны хэлтэст ажилласан
7	Т.Энхболд	45		Жилийн турш ажилласан
8	О.Ганболд		49	2018 оны 09 сараас чөлөөлөгдсөн
9	Д.Янжинлхам	41		Жилийн турш ажилласан
10	Х.Баярнаадам		5	Жилийн турш ажилласан
11	Ц.Сэргэлэн		2	Жилийн турш ажилласан
12	А.Ариунсанаа		6	Жилийн турш ажилласан
13	Н.Амарбаяр	58		2018 оны 03 сараас ХАА-ны хэлтэст даргаар ажилласан
14	С. Түмэнбаяр		10	2018 оны 05 сараас ХАА-ны хэлтэст ажилласан
15	М.Одгэрэл		4	Угтах үйлчилгээний ажилтан
16	О.Буянжаргал		3	Даргын туслах
17	С.Оюунцэцэг	5		Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
	Нийт	187	187	

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2018 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байгууллагын жагсаалт

Д/д	ХАА зохион байгуулсан байгууллага	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр		Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар		Нийслэлийн ОНХС-гийн хөрөнгөөр		Нийт	
		Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг
1	Авто худалдааны цогцолбор ОНӨААТҮГ	1	6,300,000.00	0	-	0	-	1	6,300,000.00
2	Багануур дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	2	2,088,826.76	1	170,000.0	3	414,852.39	6	2,673,679.15
3	Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	0	-	1	50,000.0	3	386,000.00	4	436,000.00
4	Баянгол дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	1,000,000.00	0	-	0	-	1	1,000,000.00
5	Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	49,737.64	0	-	0	-	1	49,737.64
6	Геодези. усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ	4	400,000.00	0	-	0	-	4	400,000.00
7	Замын хөдөлгөөний удирдлагын төв ОНӨҮГ	0	-	9	1,180,818.8	0	-	9	1,180,818.82
8	Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	284,108.00	1	170,000.0	1	170,000.00	3	624,108.00
9	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар	0	-	122	39,366,641.2	2	240,000.00	124	39,606,641.22
10	Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар	1	140,000.00	0	-	0	-	1	140,000.00
11	Нийслэлийн Байгаль орчны газар	2	150,000.00	0	-	0	-	2	150,000.00
12	Нийслэлийн Газрын алба	2	11,297,600.00	0	-	0	-	2	11,297,600.00
13	Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газар	5	10,883,800.00	0	-	0	-	5	10,883,800.00
14	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	1	1,000,000.00	0	-	0	-	1	1,000,000.00
15	Нийслэлийн Мал эмнэлгийн газар	1	32,000.00	0	-	0	-	1	32,000.00
16	Нийслэлийн Мэдээллийн технологийн газар	11	2,840,800.00	0	-	0	-	11	2,840,800.00
17	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	2	100,000.00	0	-	0	-	2	100,000.00
18	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар	4	200,000.00	0	-	0	-	4	200,000.00
19	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК	2	937,900.00	0	-	0	-	2	937,900.00
20	Нийслэлийн Өмчийн харилцааны газар	1	4,872,800.00	0	-	0	-	1	4,872,800.00
21	Нийслэлийн Үйлдвэрлэл, иновацийн газар	1	300,000.00	0	-	0	-	1	300,000.00
22	Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар	6	2,504,850.00	0	-	0	-	6	2,504,850.00
23	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨҮГ	10	55,450,223.45	0	-	24	917,000.00	34	56,367,223.45
24	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	54	9,912,893.17	0	-	19	1,171,642.77	73	11,084,535.94
25	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	14	1,257,986.00	0	-	6	491,700.00	20	1,749,686.00
26	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨҮГ	6	885,378.16	0	-	0	-	6	885,378.16
27	Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	60,000.00	0	-	1	130,000.00	2	190,000.00
28	Сүхбаатар дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	0	-	0	-	7	130,042.00	7	130,042.00
29	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	33	6,909,300.00	0	-	119	5,606,498.42	152	12,515,798.42
30	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	1	700,000.00	0	-	0	-	1	700,000.00
31	Ус сувгийн удирдах газар ОНӨҮГ	1	2,500,000.00	0	-	0	-	1	2,500,000.00
32	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨҮГ	1	355,000.00	0	-	0	-	1	355,000.00
33	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	94,790.18	0	-	2	110,000.00	3	204,790.18

34	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	2	1,505,200.00	0	-	0	-	2	1,505,200.00
35	Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	132,770.09	0	-	9	490,000.00	10	622,770.09
НИЙТ		174	125,145,963.45	134	40,937,460.0	196	10,257,735.58	504	176,341,159.07

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2019 оны эхний хагас жилд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байгууллагын жагсаалт

Д/д	ХАА зохион байгуулсан байгууллага	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр		Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар		Нийслэлийн ОНХС-гийн хөрөнгөөр		Нийт	
		Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг	Тоо	Батлагдсан төсөвт өртөг
1	Багануур дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	3	11,541,570.0	1	185,000.0	3	400,000.0	7	12,126,570.0
2	Багахангай дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	4	415,100.0	1	55,000.0	2	400,000.0	7	870,100.0
3	Баянгол дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	2	557,000.0					2	557,000.0
4	Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	2	660,000.0			16	791,900.0	18	1,451,900.0
5	Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ			7	1,522,430.2			7	1,522,430.2
6	Замын хөдөлгөөний удирдлагын төв НӨҮГ			7	1,000,000.0			7	1,000,000.0
7	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ	1	900,000.0					1	900,000.0
8	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ	3	12,000,000.0					3	12,000,000.0
9	Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	15	1,364,600.0	1	175,000.0			16	1,539,600.0
10	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар	1	168,000.0	35	23,595,569.8			36	23,763,569.8
11	Нийслэлийн Байгаль орчны газар	3	550,000.0					3	550,000.0
12	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	9	3,810,000.0					9	3,810,000.0
13	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК	2	90,000.0					2	90,000.0
14	Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ	1	900,000.0					1	900,000.0
15	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар	14	2,634,200.0					14	2,634,200.0
16	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ	1	54,700.0			5	400,000.0	6	454,700.0
17	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар	63	97,684,100.0	1	2,200,000.0	27	2,614,200.0	91	102,498,300.0
18	Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар	1	50,000.0					1	50,000.0
19	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	21	2,600,000.0					21	2,600,000.0
20	Сонгинохайрхан дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	3	8,206,000.0			26	1,200,000.0	29	9,406,000.0
21	Сүхбаатар дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	5	537,600.0			4	297,600.0	9	835,200.0
22	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ	3	381,300.0	5	10,215,100.0			8	10,596,400.0
23	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	138	20,824,000.0			115	8,072,600.0	253	28,896,600.0
24	Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ	1	700,000.0					1	700,000.0
25	Хан-Уул дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	35	557,000.0			15	800,000.0	50	1,357,000.0
26	Хот тохижилтын газар ОНӨААТҮГ	17	6,792,100.0					17	6,792,100.0
27	Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	5	608,000.0			12	1,600,000.0	17	2,208,000.0
28	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨААТҮГ	1	28,900.0					1	28,900.0
Нийт		354	174,614,170.0	58	38,948,100.0	225	16,576,300.0	637	230,138,570.0